



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар A/1550

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Г.Чагдаржав-3-301а тоот)-т байршилтай иргэн Нэргүй овогтой Ууганбаатар (ЙЮ:86051011)-ын орон сууцны зориулалттай 360 м.кв (0,03га) газрыг иргэн Дондий овогтой Нямсүрэн (ЗЮ:84042902)-д үйлчилгээтэй орон сууцны зориулалтаар нь шилжүүлж 14 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн A/112 дугаар захирамжийн иргэн Н.Ууганбаатар-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000019867 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

481210585